

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 11 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: <i>Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сар болгон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байгаатай холбогдуулан хэрэгжилт нь удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлж, байгууллагууд цаг хугацаанд тайлагнаж ажиллах. /Нийт байгууллагууд/</i>				
1.	<p>Засгийн газрын тогтоол, шийдвэрээс дүүрэгт хамааралтай 29 шийдвэр, 64 заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн газрын 46 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд байгууллагад холбогдох заалт тус бүрд төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг авахаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 3/2765 тоот албан бичгээр хэлтэс, албадад хүргүүлсэн. Хэлтэс, албадаас биелэлтийг авч нэгтгэн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.</p> <p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан дүүрэгт хамааралтай Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 1 арга хэмжээ, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 3 арга хэмжээ, нийт 4 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн О.Тунгалагт ERP хаягаар хүргүүлсэн.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	70
Үүрэг, даалгавар ХОЁР: <i>Өвөлжилтийн хугацаанд инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, машин механизм, техник тоног төхөөрөмж бэлэн байдал болон бодис, давсны нөөцийг сайтар бүрдүүлэх ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд/</i>				
2.	<p>Чингэлтэй дүүргийн 4, 5, 6, 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 110 байр, 645 аж ахуй нэгж, байгууллагад ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх 6 дугаар төв, 1, 2, 3 дугаар хорооны 96 байрны 3405 өрх, 867 аж ахуй нэгж байгууллагыг ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх 7 дугаар төв тус тус халуун хүйтэн ус, дулааны хэрэгцээг хангаж байна.</p>	халаалтын уурын зуух	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>“Ану сервис” ХХК-иас 4 сургууль, 3 цэцэрлэг, “Элбэг дулаан” ХХК-иас 18 дугаар хорооны цогцолбор байр, 1 сургууль, 2 цэцэрлэгийн инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу “Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-д нийт 1240,3 тонн давс, 49 тонн бодис, 269 м3 хайрга, дайрга нөөцлөн, давс цацдаг тусгай зориулалтын 7 автомашин 250 хүний бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн нутаг дэвсгэрт цас мөс, халтиргаа гулгааг арилгаж, бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Хот нийтийн аж ахуй болон инженерийн хангамжийн чиг үүргийн байгууллагууд хоорондоо ажлын уялдаа холбоог сайжруулах, мөн Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ажлуудыг зохион байгуулж Захирагчийн ажлын албанаас нэгдсэн удирдлага, бодлогоор хангаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Зарим хэрэгжүүлэгч агентлагууд, Хөрөнгө оруулалтын газар, Хот нийтийн аж ахуй болон инженерийн хангамжийн байгууллагууд/</p>				
3.	<p>Дүүргийн 6 дугаар хорооны “Шилтгээн-61” СӨХ, ОСНААУГ-тай хамтран 62 дугаар байрны гадна дулааны шугамыг засварласан. Хот нийтийн аж ахуй болон инженерийн хангамжийн чиг үүргийн байгууллагууд ажлын уялдаа холбоог сайжруулах, Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 65 СӨХ-д Монголын Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлтэй хамтран түвшин тогтоох үзлэг шалгалтыг зохион байгууллаа. Үзлэг шалгалтаар “Бат-холбоо 40” СӨХ 2 дугаар байрт, “Ялалт” СӨХ 3 дугаар байрт шалгарч, “Ирээдүй 3” СӨХ, “Чандмань” СӨХ, “Дөчийн анхдагч” СӨХ-д тус бүр шалгагдсан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Манай хороо-Миний гудамж аян” -ны “Шилдэг СӨХ” шалгаруулах төрлийн тусгай байранд “Дөчийн анхдагч” СӨХ шалгарсан.</p>		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	70
<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх, борлуулах, нөөцлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” А/1349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Дүүргийн Засаг дарга нар, Бусад байгууллагууд/</p>				
4.	<p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлтийг 4 компани хариуцан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш борлуулалтын нийт 92 цэг ажиллаж байна. 2022 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 09-ний өдрийн хугацаанд нийт 14,935 тонн сайжруулсан шахмал түлш борлуулагдсан байна. Борлуулалтын 77 цэг сайжруулсан шахмал түлшний нөөцтэй, 15 цэг түлшний нөөцгүй байна. Дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 622,5 тонн сайжруулсан шахмал түлшний нөөцтэй байна. Чингэлтэй дүүргийн 7-20, 24 дүгээр хороодын агаарын бохирдлын хэмжээ өндөр цэгүүдийг тогтоосон.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	90

	<p>“Таван толгой түлш” ХХК-иас энгийн уламжлалт зуухтай 1846 айл өрхөд түлш хэмнэгч, тугааг дахин шатаах зориулалттай, угаарын хийнээс сэргийлэх “Бортого”-ыг суурилуулсан.</p> <p>Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж “Яндангаа хөөлье-Өнтэй өвөлжье” хэвлэмэл хуудасны хамт хүргүүлэн ажиллалаа.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас бэлтгэсэн “Орчны бохирдлыг бууруулахад иргэн бүрийн оролцоо” зөвлөмж-521 ш, зуух галлах заавар 505 ш, угаарын хий мэдрэгч 460 ш, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх 516 ширхэг сэрэмжлүүлгийг хордлогод өртөх эрсдэлтэй зорилтод бүлгийн 502 өрхөд хүргүүлэн ажиллалаа.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/174 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/72 захирамжаар хамтран баталсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам, нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 03 дугаар хурлын тэмдэглэл, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1357 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2022 оны “Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түүхий нүүрсний хяналтыг эрчимжүүлэх тухай” А/258 дугаар захирамж, Онцгой комиссын даргын 2022 оны 04 дүгээр албан даалгавар, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газрын бүрэлдэхүүн сайжруулсан шахмал түлшний 78 цэгүүдийн нөөц хүртээмж, худалдан борлуулалтын байдалтай танилцсан.</p> <p>Угаарын хийн хордлогын дуудлага мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.</p> <p>Гүнтийн давааны байнгын ажиллагаатай цэгт дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, нийслэлийн Цагдаагийн газраас тус бүр 3 алба хаагч 24 цагаар тогтмол хяналт тавин, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ТАВ: <i>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах. /Нийт байгууллагууд/</i></p>				
5.	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд сайжруулсан шахмал түлшний нөөцийн мэдээг өдөр тутамд тогтмол авч, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дүүргийн 7-20, 24 дүгээр хороодын сайжруулсан шахмал түлшний нөөц, борлуулалт, хангалт, түгээлт, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж хамтран ажиллах талаар 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллагын төлөөлөлтэй хамтарсан Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Уг Ажлын хэсгийн хурлаар өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж ажиллах албан хаагчдын хуваарь, төлөвлөлтийг гарган нэгдсэн зохион байгуулалтад орж ажиллах бэлтгэл ажлыг бүрэн хангасан.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90

Үүрэг, даалгавар ЗУРГАА: Дүүргүүдийн нутаг дэвсгэрт халиа дошин үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, халиа дошин үүсдэг газар зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй буусан айл, өрхийн судалгаа болон зөвшөөрөл олгосон албан тушаалтны судалгааг нарийвчилсан гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах. /Захирагчийн ажлын алба, Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Онцгой байдлын газар, Геодези, усны барилга байгууламжийн газар/				
6.	<p>Дүүргийн 17 дугаар хорооны Баянхайрханы 4 дүгээр гудамжны 78-95 тоот өрхүүдийн гудамжны бороо, хөрсний ус зайлуулах суваг эвдэрснийг засварлуулахаар Засаг даргын Тамгын газрын даргын 3/2459 тоот албан бичгээр Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн 14 дүгээр хорооны халиа дошин үүсдэг байршилд нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Гүн нуур гэрэл” ХХК-ийн арын жалга, Хайлаастын гудамжинд далан барих төсөл арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлж, 70%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ДОЛОО: Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлогын тасалдлыг нөхөж, гүйцэтгэлийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн орлого төвлөрүүлэгч байгууллагууд/				
7.	<p>Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 118,951,505 мянган төгрөг, гүйцэтгэл 114,505,314 мянган төгрөг буюу 96%-тай байна. Дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт 73,809,338 мянган төгрөг төвлөрүүлэхээс 60,665,209.9 мянган төгрөг төвлөрүүлж, 82,1%-ийн биелэлттэй байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар НАЙМ: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, үргүй зардлыг багасгаж, нийслэлийн өмчийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч, хэрэгжилтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс тогтмол хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нийт байгууллагууд/				
8.	<p>Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 дугаар албан бичгээр, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллахыг 4/1596 дугаар албан бичгээр, төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг даргын 2022 оны 1/1745 тоот албан бичгээр харьяа 69 байгууллагын төсвийн шууд захирагч нарт тус тус хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан.</p> <p>Өмчийн эд, хөрөнгийн улсын үзлэг тооллогоор дүүргийн харьяа хэлтэс, алба, төр захиргааны байгууллага 17, цэцэрлэг 39, сургууль 18, өрхийн Эрүүл мэндийн төв 16 нийт 90 байгууллага хамрагдахаас 100% хамрагдсан.</p> <p>Улс, нийслэл орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 23 төрлийн 2,182,976,862 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэн авсан. Дүүргийн Засаг даргын 2020 оны А/473 дугаартай захирамжаар томилогдсон Ажлын хэсэг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 61 ажлыг хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан ба холбогдох материалын бүрдлийг хангуулан хүлээж авч, гэрээг дүгнэн ажиллалаа.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/330 дугаар захирамжаар төсөвт өр авлага үүсгэхгүй, зохистой удирдлага хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн зарлага, сургууль цэцэрлэгийн төсвийн хуваарьт тус тус өөрчлөлт оруулсан.</p>			
<p>Үүрэг, даалгавар ЕС: <i>“Digital city” төслийн хүрээнд хийгдэж байгаа хэсгийн ахлагч, онлайн бизнес төв, E-school, хүүхдийн автобусны техникийн шийдлүүдийг нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах /Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар, Замын хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Замын цагдаагийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Нийтийн тээврийн газар, Дүүргийн Засаг дарга нар/</i></p>				
9.	<p>Дүүргийн хэмжээнд “E-school” системийг Ерөнхий боловсролын 7 сургууль бүрэн нэвтрүүлсэн. “E-school” үнэмлэхийг 10,520 сурагчдад тарааж, 10,508 сурагчдын мэдээллийг баталгаажуулсан. “E-school” аппликэйшнд багш, ажилчдын мэдээлэл 100%, эцэг эхийн гар утсан дээрх татан авалт 58%-тай явагдаж байна.</p> <p>НЗДТГ-аас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн Ерөнхий боловсролын 37, 117, 149 дүгээр сургуулиудад хүүхдийн автобус эзэмшүүлэх эрхийн бичгийг гардуулсан.</p> <p>Сурагч хүүхдүүдийн ая тухтай, аюул осолгүй зорчих нөхцөл бүрдсэн, техникийн хувьд “Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага” MNS 4598:2011 стандартын үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан автобусаар дүүргийн нутаг дэвсгэрийн Ерөнхий боловсролын төрийн өмчийн 20 сургуулиас 6, төрийн бус өмчийн 9 сургуулиас 2 сургууль нийт 6 автобусаар тус тус үйлчилж байна.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэр, сургуулийн бүсэд хүүхдийн автобус аюулгүй буулгах, суулгах зогсоол талбайг чөлөөлж, чиглэл маршрутыг тодорхой оруулсан. Зорчигч хүүхдэд GPS бугуйвч суулгаж, эцэг эхийн гар утсанд мэдээ мэдээлэл өгөх төхөөрөмжийг холбон өгч, хүүхдийг болзошгүй зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p>Үүрэг, даалгавар АРАВ: <i>Нийтийн эзэмшлийн гудамж, авто зам, орон сууц, гэр хорооллын дундах авто зам, аж ахуй нэгж байгууллагуудын ойр орчмын 50 метр хүртэлх талбайн цас, хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг эрчимжүүлэх. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар Бусад байгууллагууд/</i></p>				
10.	<p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 61, 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн нэгдсэн цахим Фэйсбүүк, пейж хуудсаар нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудад өөрийн эзэмшлийн болон ойр орчны 50 метр дэх цас, мөсийг арилган цэвэрлэгээ хийх чиглэл өгч, мэдээллийг худалдааны 157, ахуйн үйлчилгээний 43 нийт 100 иргэн, аж ахуйн нэгжид хүргэсэн. Дүүргийн 1-20, 24 дүгээр хорооны ажлын албаар дамжуулан орчны 50 метрийн цэвэрлэгээг хийлгэн, хэрэгжилтийг хангуулан ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн нэгдсэн цахим Фэйсбүүк, пейж хуудсаар дамжуулан ААНБ-д хариуцсан бүсийн 50 метр хүртэлх зам талбайг цас орсон даруйд цэвэрлэх, иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийхийг уриалан ажиллаж байна.</p>		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт хөндлөнгийн хяналтын “ЭЭХХүрээлэн” ТББ-тай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Тус ажлын хүрээнд гаднах зам талбайг цэвэрлээгүй нийт 89 иргэн, аж ахуй нэгж байгууллагад шаардлага хүргүүлэн цаг тухайд нь цэвэрлэгээ үйлчилгээг хийлгэсэн. Нийт 881 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 35,240 м² талбайд цэвэрлэгээ хийсэн.</p> <p>Дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу “Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-д нийт 1240,3 тонн давс, 49 тонн бодис, 269 м3 хайрга, дайрга нөөцлөн, давс цацдаг тусгай зориулалтын 7 автомашин, 250 хүний бүрэлдэхүүнтэйгээр нутаг дэвсгэр дэх цас мөс, халтиргаа гулгааг тогтмол цэвэрлэн ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: <i>Иргэдэд ая тухтай орчин бүрдүүлэх чиглэлээр 2023 онд /явган болон дугуйн зам, нийтийн эзэмшлийн гудамж, замын тохижилт, ногоон байгууламж/-ийг нэмэгдүүлэх тооцоо судалгаа, ТЭЗҮ, байршил зэргийг тооцож боловсруулах ажлаа шуурхай зохион байгуулах. /Захирагчийн ажлын алба, Хот байгуулалт, хөгжлийн газар, Газар зохион байгуулалтын алба, Хот төлөвлөлт, судалгааны институт, Дүүргийн Засаг дарга нар Инженер хангамжийн байгууллагууд/</i></p>				
11.	<p>Дүүргийн 1-20, 24 дүгээр хороодын иргэдээс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг цаасан болон цахим хэлбэрээр авч ажиллалаа. Ирүүлсэн хүсэлтийн дагуу гудамж, талбайн тохижилтыг сайжруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх, явган хүний болон авто замын засвар, шинэчлэлт хийх, нийтийн зориулалттай талбайд амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай байгуулах, засварлах ажлуудын байршлыг тодорхойлон 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагуудын хуралдаанаар танилцуулсан. Тус хуралдаанаар өгөгдсөн үүргийн дагуу газар дээр нь хэмжилт, тооцоо судалгааг гарган ажиллалаа.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p>Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: <i>2022 онд Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тендер, сонгон шалгаруулалтад оролцож ажлаа гүйцэтгэхгүй байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын жагсаалтыг гаргаж, иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Дүүргийн Засаг дарга нар болон бусад байгууллагууд/</i></p>				
12.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/250 дугаар тушаалаар дүүргийн нутаг дэвсгэрт Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт тавих, газар дээр нь шалгах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Ажлын хэсэг нь 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцтай танилцан, хяналт тавин ажиллалаа.</p> <p>Үүнд: /Удаашралтай байгаа/ ➢ Дүүргийн 19 дүгээр хороонд 240 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор ажлын явц 60%-тай ажил зогссон. /2019-2022 он дамжин хэрэгжиж, нэмэлт ажлын санхүүжилт батлагдаагүй, санхүүжилтийн хүсэлтийг Барилга хөгжлийн төвд хүргүүлсэн/</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<ul style="list-style-type: none"> ➤ Дүүргийн 12 дугаар хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын явц 70%-тай, сургуулийн дотор засал хийгдээгүй. /2018-2022 онд он дамжин хэрэгжиж байна/ ➤ Дүүргийн 13 дугаар хороонд баригдаж буй Эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл (Хайлааст салбар) өнөөдрийн байдлаар 30%-тай, шалгалтын явцад ажил зогссон байна. ➤ Дүүргийн 8 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлын явц 10%-тай. Барилга баригдах газар 1 өрх, айл газар өмчлөх эрхийн асуудлаар маргаантай, тухайн өрх, айлтай зөвшилцлийн шатанд байна. <p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тендер, сонгон шалгаруулалтад оролцон шалгарсан аж, ахуй нэгж байгууллагууд гэрээгээр хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэж байна.</p>			
--	--	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН
НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ДУЛМАА

Т.ТҮВШИНЖАРГАЛ